



# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## “ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2025 оны 12 дугаар сар

### АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр эхлүүлж, хуанлийн 3 хоногт гүйцэтгэсэн нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл боллоо.

**АУДИТЫН ГОЛ ҮР ДҮН (НӨХЦӨЛ БАЙДАЛД СУУРИЛСАН ДҮГНЭЛТ):**

#### **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

**1. АЙМГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД САНГИЙН ЯАМНААС ХЯНАСАН ОРЛОГЫГ СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН 15,454.1 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

Сангийн яамнаас аймгийн 2026 оны төсвийн нийт орлогыг 97,520.7 сая төгрөгөөр хянасныг аймгийн төсвийн төсөлд 15,454.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 112,974.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Өмнө оны төсвийн төсөлтэй харьцуулахад 5,411.5 сая төгрөгөөр **бууруулсан** байна.

Дорноговь аймгийн 2026 оны төсвийн орлогыг Сангийн яамнаас 97,520.7 сая төгрөгөөр хянасныг аймгийн төсвийн төсөлд 15,454.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 112,974.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүний **89.7** хувийг татварын орлого, **4.6** хувийг татварын бус орлогоор, **4.4** хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Орон нутгийн суурь төсвийн хувьд Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд зэрэг 9 сум, сумын татварын болон татварын бус орлогоосоо бие даан өөрийгөө санхүүжүүлэхээс гадна аймгийн төсөвт нийт 59,313.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр тооцсон нь 2025 оны тодотгосон төсвийг 11,494.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН НЭР, ТӨРЛӨӨР НЬ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРУУЛАН ТООЦСОН БАЙНА.**

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орон нутгийн төсвийг татварын болон татварын бус орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан.

№	Орлогын төрөл	Сангийн яамны хянасан дүн	Аймгийн төсвийн төслийн дүн
1	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>97,520.72</b>	<b>112,974.77</b>
2	<b>Татварын орлого</b>	<b>93,041.34</b>	<b>107,767.92</b>
3	Орлогын албан татвар	72,450.4	72,950.36
4	Хувь хүний орлогын албан татвар	55,020.36	55,520.36
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,420.00)	(2,420.00)
6	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	17,430.00	17,430.00
7	Хөрөнгийн албан татвар	5,190.83	9,526.83
8	Бусад татвар, төлбөр, хураамж	15,400.16	25,290.74
9	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,720.00	11,720.00
10	Газрын төлбөр	3,000.00	6,000.00
11	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,180.16	1,196.15
12	<b>Татварын бус орлого</b>	<b>4,479.38</b>	<b>5,206.85</b>
13	Нийтлэг татварын бус орлого	4,464.38	5,166.85
14	Хөрөнгийн орлого	15.00	6,414.59

/сая төгрөгөөр/

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлогыг Сангийн яамнаас 23 нэр төрлөөр хянаж ирүүлснийг аймгийн төсвийн төсөлд төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмж, газрын тосны орлогыг бусад орлогод оруулан хасаж, 23 нэр төрлөөр төлөвлөсөн байна.

### 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ 2,350.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын нэр төрөл бүрээр үзэхэд хувь хүний орлогын албан татварыг 850.0 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- ▶ **ХХОАТ:** Монголын Боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Засгийн газартай зөвшилцөн багш нарын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 хувь, 7 дугаар сараас 10 хувиар нэмэх зөвшилцөлд хүрсэн. Аймгийн хэмжээний 23 ерөнхий боловсролын сургууль, 34 сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 2138 багш, ажилчид ажилладаг бөгөөд цалингийн санг 30 хувиар нэмэхэд 18,850.9 сая төгрөгөөр өсөж, хувь хүний орлогын албан татварыг сүүлийн 3 улирлаар тооцоолоход 850.0 сая төгрөг орон нутгийн төсөвт нэмж төвлөрүүлэх боломжтой байна.
- ▶ **ТОРГУУЛИЙН ОРЛОГО:** Аймгийн Прокурорын байгууллагаас ирүүлсэн судалгаагаар Дорноговь аймагт зөрчил шалган шийдвэрлэх 31 байгууллагын 594 ЭБАТ байна. Эдгээр ЭБАТ-уудаас 2023 онд 36,615 зөрчилд **3,400.5 сая төгрөгийн**, 2024 онд 50,342 зөрчилд **4,696.1 сая төгрөгийн** торгуулийг оногдуулж, нийт 7,719.7 сая төгрөгийн торгуулийг төвлөрүүлсэн байна. Нийт төвлөрсөн 7,719.7 сая төгрөгийн торгуулийн орлогын 39 хувь буюу 3,006.4 сая төгрөг нь **УЛСЫН ТӨСӨВТ**, 60.9 хувь буюу 4,702.4 сая төгрөг нь орон нутгийн төсөвт, 0.1 хувь буюу 10.8 сая төгрөг нь **БАЙГУУЛЛАГЫН ДАНСАНД** төвлөрсөн байна.

№	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Нэг зөрчлийн дундаж торгуулийн дүн	Зөрчлийн тоо (өсөлттэй)	Төвлөрүүлэх боломжтой торгуулийн мөнгөн дүн
<b>Улсын төсөвт төвлөрүүлдэг байгууллага</b>				
1	Мал эмнэлгийн газар	0.15	-	-
2	Авто тээврийн Үндэсний төвийн байгууллага	0.16	41.00	6.69
3	Гаалийн байгууллага	1.45	944.50	1,371.03
4	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	0.71	3.50	2.47
5	Байгаль орчны газар	2.07	32.50	67.30
6	Хүнс, хөдөө аж ахуйн газар	1.06	28.50	30.16
7	Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын газар	0.69	-	-
8	Эрүүл мэндийн газар	0.81	14.00	11.33
9	Хилийн цэргийн байгууллага	0.19	59.50	11.15
<b>Нийт</b>		<b>7.28</b>	<b>1,123.50</b>	<b>1,500.12</b>
<b>Байгууллагын дансанд төвлөрүүлдэг байгууллага</b>				
1	Стандарт, хэмжил зүйн хэлтэс			0.16
<b>Нийт</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>0.16</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>7.28</b>	<b>1,123.50</b>	<b>1,500.28</b>

Дээрх хүснэгтэд торгуулийн орлогын зөрчлийн тоог өсөлтийн хувиар тооцоолоход торгуулийн орлогыг жилд дунджаар 1,500.0 сая төгрөгөөр **НЭМЭГДҮҮЛЭХ** боломжтой байна.

**4. ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАРЛАГЫГ ХОЛБОГДОХ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН 41,917.8 СЯА ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.**

Дорноговь аймгийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 180,561.3 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн санал боловсруулан, Сангийн яаманд хүргүүлж, УИХ-аас баталсан МУ-ын 2026 оны Төсвийн тухай хуулиар 2026 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 60,072.5 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 120,488.8 сая төгрөгөөр бууруулж хянасан байна.

Сангийн яамны хянасан суурь зарлага 60,072.5 сая төгрөгийн төсвийг аймгийн 2026 оны төсвийн төсөлд 41,917.8 сая төгрөгөөр нэмэн 101,990.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

**5. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ЗАРЛАГЫГ ӨМНӨ ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 36,028.5 СЯА ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

Аймгийн төсвийн төсөлд нийт зарлагыг 101,990.3 сая төгрөгөөр тооцсон бөгөөд 79.9 хувь буюу 81,462.5 сая төгрөгийг урсгал зардалд, 20.1 хувь буюу 20,527.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн суурь төсвөөс Айраг, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Улаанбадрах зэрэг 5 суманд нийт 1,943.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор тусгажээ. Алтанширээ, Эрдэнэ сумд аймгаас санхүүгийн дэмжлэг авахаа больж, аймгийн төсөвт төвлөрүүлдэг болсонтой холбоотой 2025 оны тодотгосон төсвөөс 1,097.5 сая төгрөгөөр буурсан нь байна.

Төсвийн зарлагын төлөвлөлтөд Монгол Улсын Засгийн газраас төсвийн хувьд баримталж байгаа бодлого, чиглэл, шинэчлэлийн зарчмуудыг баримтлан

“Дорноговь аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан хөтөлбөр, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээтэй уялдуулан үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн арга зүйг ашиглан төлөвлөжээ.


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний чиг үүргийн хүрээнд аймаг дахь Политехникийн коллеж, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Нэгдсэн эмнэлгүүд болон Биеийн тамир, спортын газар, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Номын сан, сумын соёлын төвүүдийн байр ашиглалттай холбоотой зардал болох гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр, бохир ус, түрээс, урсгал засварын зардалд 18,719.7 сая төгрөгийг төсөвт тусгасан.

Орон нутгийн урсгал зардлын суурь зарлагыг аргачлалын дагуу тооцож үзэхэд Сангийн яамны хянасан урсгал зардлын төсвийг 41,917.9 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 36,025.5 сая төгрөгөөр буурсан байна.

#### **6. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЖ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХДОО ТУХАЙН БАЙГУУЛЛАГА, СУМААС ИРСЭН САНАЛД ҮНДЭСЛЭН ГАРГАСАН БАЙНА.**

Орон нутгийн төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын 17,125.6 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ, их засварын зардалд 3,202.2 сая төгрөгийн 7, зам, зам засварын ажилд 2,996.0 сая төгрөгийн 4 ажлыг тус тус санхүүжүүлж, ОНХС-ын 32,308.2 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжих 17,325.6 сая төгрөгийн 34 ТАХ тусгасан байна. Үүнд өмнөх оноос шилжсэн 19 ТАХ-нд 4,199.0 сая төгрөг, шинээр хэрэгжих 15 ТАХ-нд 13,126.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ. Харин их засварын 7 ТАХ-д 3,202.0 сая төгрөг төсөвлөжээ.



Өмнө онуудад барилга, байгууламжийг паспортжуулах ажлыг ОНХО-аар хэрэгжүүлэн “Засварлах, хүчитгэхэд оновчгүй” дүгнэлттэй барилгад их засварын ажлыг үр дүнгүй хэрэгжүүлсэн зөрчил илэрч байсан тул зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах нь зүйтэй.

Аймгийн 2026 оны хөрөнгө оруулалтын жагсаалтыг аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорноговь аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхтэй уялдуулан төлөвлөсөн боловч холбогдох хууль, тогтоомжид заасан зарим төлөвлөлтийн шаардлага хангаагүй болон эдийн засгийн үр ашгийн тооцоо судалгаа хийгээгүй Зам засварын ажлын нөхөөс хийх техник хэрэгсэл худалдан авах ажлын төсөвт өртгөөс **шаардлагагүй** 173.0 сая төгрөгийн 2 хөрөнгийг төлөвлөсөн байна.

**7. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН 213.0 САЯ ТӨГРӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ БАЙНА.**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан байна. Харин аймгийн Засаг даргын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд тусгасан зарим төсөл, хөтөлбөрийн зардал Төрийн хэмнэлтийн хуульд нийцэхгүй байна.

Дорноговь аймгийн Засаг даргын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд нийт 17 хөтөлбөрийн 8,841.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнээс 213.0 сая төгрөгийн 4 төсөл, хөтөлбөр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөл, хөтөлбөрийг хариуцагч байгууллага	Төлөвлөсөн төсөв (сая төгрөгөөр)
1	"Бага олимп-2026" спортын арга хэмжээ зохион байгуулах	Биеийн тамир, спортын газар	110.0
2	Улс, тив, дэлхий, олимпын тэмцээнд амжилт гаргасан дасгалжуулагч, тамирчдад урамшуулал олгох	Биеийн тамир, спортын газар	60.0
3	Сургууль, цэцэрлэгийн суралцагчдын дунд "Дорноговь робот" бүсийн уралдаан зохион байгуулах	Боловсролын газар	15.0
4	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр суралцагчдыг гадаад хэлний бэлтгэл, тэтгэлэгт хамруулах	Боловсролын газар	28.0
<b>Нийт мөнгөн дүн</b>			<b>213.0</b>

Иймд тус хуулийн заалтад нийцэхгүй байгаа 213 сая төгрөгийн 4 төсөл хөтөлбөрийг орон нутгийн төсвөөс хасах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

**8. ТӨСВИЙН ТӨСӨЛД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН АЖЛУУДЫГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

Аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого -Тасралтгүй хөгжил” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан Дорноговь аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөг боловсруулан баталсны дагуу орон нутгийн төсвийг уялдуулан боловсруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-д аймгийн хөгжлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилтод хамаарахгүй ТАХ байхгүй байна.

## ЗӨВЛӨМЖ:

### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Н.АЛДАРБАЯР ТАНАА**

1. Орон нутгийн төсвийн орлогод хувь хүний орлогын албан татварын орлогыг 850.0 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 1,500.0 сая төгрөгөөр тус тус нэмж нийт орлогыг 2,350.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
2. Зам засварын ажлын нөхөөс хийх техник хэрэгсэл худалдан авах ажлын төсөвт өртгөөс шаардлагагүй 173.0 сая төгрөг 2 нэрийн хөрөнгийг хасах
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3,096.5 сая төгрөгийн 4 ТАХ-д тооцоо, үр нөлөөг тооцож оруулах
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.8-т “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин 213.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг хасах
5. Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т “Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөр хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана” гэж заасны дагуу хурлын явцад төлөөлөгчдийн гаргасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг оруулах

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА**

1. Орон нутгийн төсвийн орлогод хувь хүний орлогын албан татварын орлогыг 850.0 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 1,500.0 сая төгрөгөөр тус тус нэмж нийт орлогыг 2,350.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх
2. Зам засварын ажлын нөхөөс хийх техник хэрэгсэл худалдан авах ажлын төсөвт өртгөөс шаардлагагүй 173.0 сая төгрөг 2 нэрийн хөрөнгийг хасах
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3,096.5 сая төгрөгийн 4 ТАХ-д тооцоо, үр нөлөөг тооцож оруулах
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.8-т “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин 213.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг хасах